

ГОМДЛЫГ БАРАГДУУЛАХ ҮЕ ШАТУУД:

Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу 30 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд 30 хүртэлх хоногоор дахин сунгаж болно.



ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ

Өргөдөл, гомдол хариуцсан ажилтнууд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн аван бүртгэж, хүлээн авсан талаар гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.



ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХЯНАХ

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд хүлээн авсан өргөдөл, гомдлыг төслийн үйл ажиллагаанд хамаарах эсэхийг нягтална. Хэрэв асуудлыг цаашид шалган шийдвэрлэх бол өргөдөл, гомдлыг хариуцах албан тушаалтанд шилжүүлнэ.



ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

Өргөдөл, гомдол хариуцсан албан тушаалтан өргөдөл, гомдол дурдсан асуудлыг хянан судалж, түүний мөрөөр авах арга хэмжээг удирдлагад танилцуулна. Гомдлыг удирдах албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.



ГОМДОЛ ГАРГАГЧИД ХАРИУ ӨГӨХ

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг амаар, утсаар, цахим сүлжээгээр, эсхүл албан бичгээр зэрэг тохиромжтой хэлбэрээр гомдол гаргагчид мэдэгдэнэ. Хэрэв гомдол гаргагч нь шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дараагийн шатны төрийн байгууллагууд болон Дэлхийн банкны Өргөдөл гомдол шийдвэрлэх үйлчилгээнд гомдлоо гаргаж болно.



Гомдол гаргагчийн мэдээллийг "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" МУ-ын хуульд заасны дагуу нууцлан хадгална.

ХОЛБОО БАРИХ:

🏠 Сан Бизнес центр, 501 тоот, Ерөнхий Сайд Амарын гудамж-29, Бага тойруу, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот, Монгол улс

☎ 75057570
🌐 www.mesp.mn
✉ info@mesp.mn
📌 <https://www.facebook.com/Mongolia.Employment.Support.Project>

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ





ТӨСЛИЙН ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ ГЭЖ ЮУ ВЭ?

Гомдол барагдуулах механизм нь төслийн үр шим хүртэгч, гэрээт ажил гүйцэтгэгч, төсөлд оролцогч талууд болон төслийн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртөж болзошгүй иргэн, олон нийт санал хүсэлтээ илэрхийлж, дуу хоолойгоо хүргэх гол хэрэгсэл юм.

Талуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр үр дүнтэй, түргэн шуурхай шийдвэрлэх, төслийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, шударга, үр дүнтэй хэрэгжүүлэх, ил тод байдлыг бий болгоход гомдол барагдуулах механизмын зорилго оршино.



ЯМАР ТОХИОЛДОЛД ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАЖ БОЛОХ ВЭ?

- Төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд болон тэдгээрийн үйл ажиллагаа нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журам зөрчсөн;
- Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор таны мэдээлэл авах эрх хязгаарлагдсан, ялгаварлан гадуурхагдсан, төслийн үйл ажиллагаанд хөндлөнгийн этгээдийн зохисгүй оролцоо илэрсэн;
- Төслийн үйл ажиллагаанд оролцогч талууд залилан болон хээл хахууль авсан, эсвэл төслийн дүрэм, журам зөрчсөн;
- Төслийн хүрээнд хэрэгжүүлж буй аливаа үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд ямарваа нэгэн сөрөг нөлөөлөл учруулсан;
- Бусад хэлбэрээр нөлөөлөлд өртсөн, өртөж болзошгүй гэж үзэж буй иргэд, олон нийт гомдол гаргаж болно.



ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭДЭГ ВЭ?

Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүссэн гомдлыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль болон төслийн гомдол барагдуулах механизмд тулгуурлан шийдвэрлэнэ. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь гомдлыг бие даан шийдвэрлэх эрхгүй бөгөөд өргөдөл гомдлыг шийдвэрлэх эрх хэмжээнд хамаарах байгууллагад шилжүүлж, гомдлыг шийдвэрлэх үйл явцыг зохицуулах, гомдол гаргагчид эцсийн хариуг өгөх болон гомдол барагдуулах механизмын үйл ажиллагааны талаар тайлагнаж ажиллана.



ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ЯМАР СУВГААР ХҮЛЭЭН АВАХ ВЭ?

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтнүүд төслийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг доор дурдсан сувгаар байнга хүлээн авна.



№	Байгууллагын нэр	Холбоо барих	Хаяг
1	ХЭДТ-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгж	Төслийн вэбсайтад байрлах гомдол хүлээж авах цонх www.mesp.mn болон доорх утас, цахим шуудангаар дамжуулан гомдлыг хүлээн авна. ✉ info@mesp.mn ☎ +976-75057570	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу 14200, Ерөнхий сайд Амарын гудамж, Сан бизнесийн төв, 501 тоот.
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	✉ info@mlsp.gov.mn 🌐 www.mlsp.gov.mn ☎ +976-51-261553 +976-51-267635	Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, НҮБ-ын гудамж
3	Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний Ерөнхий газар	✉ info@hudulmurhalamj.gov.mn 🌐 hudulmur-halamj.gov.mn ☎ +976 7731 5091	Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон
4	Аймаг дүүргийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар, хэлтэс (ХХҮГ/Х)	ХХҮЕГ-ын www.hudulmur-halamj.gov.mn цахим хуудаснаас, 21 Аймаг, 9 дүүргийн ХХҮГГазар, хэлтсүүдтэй холбогдох мэдээллийг авна уу.	ХХҮЕГ-ын www.hudulmur-halamj.gov.mn цахим хуудаснаас, 21 Аймаг, 9 дүүргийн ХХҮГГазар, хэлтсүүдийн хаягийг харна уу.

Гомдлыг төсөл хэрэгжих хугацааны аль ч үед гаргаж болно. Өргөдөл, гомдлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бичгээр, амаар болон цахим хэлбэрээр гаргаж болно.